

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ2022 оны 03 сарын 21 өдөрДугаар: 03

Улаанбаатар хот

Компанийн зохион байгуулалтын бүтэц,
орон тооны хязгаар батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дэх заалт, 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9 дэх заалт, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3, Гүйцэтгэх захирлын 2022 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод (журам) хэм хэмжээ”-ний 2.8.3-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний давхар даатгал” ХК-ийн зохион байгуулалтын бүтцийг 1 дүгээр хавсралтаар, орон тооны хязгаарыг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарт багтаан компанийн хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” 02/13 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.


4. Энэхүү тогтоолыг 2022 оны 3 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



З.ЭНХБОЛД


“Үндэсний давхар даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 03 дугаар тогтоолын 1 дүгээр ХАВСРАЛТ



“ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ” ХК-ИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ



“Үндэсний давхар даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 03 дугаар тогтоолын 2 дугаар ХАВСРАЛТ



**“ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ” ХК-ИЙН
ОРОН ТООНЫ ХЯЗГААР**

| Д/д | Албан тушаалын нэр | Орон тоо |
|--|--|-----------|
| 1 | Гүйцэтгэх захирал | 1 |
| 2 | Дэд захирал /Хөрөнгө оруулалт хариуцсан/ | 1 |
| 3 | Дэд захирал /Эрсдэл хариуцсан/ | 1 |
| 4 | Дотоод хяналтын ажилтан | 1 |
| Андеррайтингийн газар | | |
| 5 | Андеррайтингийн газрын дарга | 1 |
| 6 | Удирдлагын мэдээллийн системийн мэргэжилтэн | 1 |
| 7 | Ахлах андеррайтер | 2 |
| 8 | Андеррайтер | 7 |
| Бизнес хөгжил, төслийн газар | | |
| 9 | Бизнес хөгжил, төслийн газрын дарга | 1 |
| 10 | Давхар даатгалын ахлах менежер | 1 |
| 11 | Төслийн ахлах менежер | 1 |
| 12 | Төслийн менежер | 1 |
| 13 | Шинэ бүтээгдэхүүн хариуцсан ажилтан | 2 |
| 14 | Давхар даатгалын менежер | 2 |
| 15 | Маркетингийн менежер | 1 |
| Комплаенс, нөхөн төлбөрийн газар | | |
| 16 | Комплаенс, нөхөн төлбөрийн газрын дарга | 1 |
| 17 | Ерөнхий хуульч | 1 |
| 18 | Үйл ажиллагаа хариуцсан эрх зүйч | 1 |
| 19 | Нөхөн төлбөрийн менежер | 2 |
| Эрсдэлийн менежмент, хөрөнгийн удирдлагын газар | | |
| 20 | Эрсдэлийн менежмент, хөрөнгийн удирдлагын газрын дарга | 1 |
| 21 | Ахлах актуарч | 1 |
| 22 | Эрсдэлийн ахлах шинжээч | 1 |
| 23 | Актуарч | 1 |
| 24 | Хөрөнгө оруулалтын шинжээч | 2 |
| Захиргаа, удирдлагын газар | | |
| 25 | Захиргаа, удирдлагын газрын дарга | 1 |
| 26 | Мэдээлэл технологийн ажилтан | 1 |
| 27 | Хүний нөөцийн ажилтан | 1 |
| 28 | Архив, бичиг хэргийн ажилтан | 1 |
| 29 | Жолооч | 2 |
| Санхүүгийн алба | | |
| 30 | Ерөнхий нягтлан бодогч бөгөөд Санхүүгийн албаны дарга | 1 |
| 31 | Ахлах нягтлан бодогч | 1 |
| 32 | Нягтлан бодогч | 1 |
| 33 | Худалдан авалт хариуцсан ажилтан | 1 |
| Нийт орон тоо | | 45 |